



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/050/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа

Утас: 7033-3019

Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.14 № 04

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЙРХАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА О.ЮМЖИРДУЛАМ  
ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хайрхан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний ажлын болон төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй байхад 15,750.0 мянган төгрөгийг зарцуулсан;
2. Тайлант хугацаанд цалингийн батлагдсан сангаас 1,050.0 мянган төгрөгийг албан хаагчдад түлшний үнийн хөнгөлөлтөд олгож зориулалт бус зарцуулсан;

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тушаалаар баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд Архангай аймгийн Хайрхан сумын түүхт 100 жилийн ойг тохиолдсон бөгөөд төсвийн хөрөнгөөр 5700.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 5300.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авч үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2024 онд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагаа, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг, гэмт гэргээс урьдчилан сэргийлэх нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 207,046.0 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 179,498.3 мянган төгрөгийг зарцуулж, 27,547.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн үлдэгдэл нь цалингийн санг өндөр дүнгээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хайрхан сумын ИТХ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 22 арга хэмжээг 100 %, 12 арга хэмжээ 90 хувь биелүүлж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын ИТХ-аас 96.6 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	856,400.00	867,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	856,400.00	867,200.00
354	Хангамжийн материал	856,400.00	867,200.00
3541	Бичиг хэргийн материал	188,500.00	199,300.00
3542	Аж ахуйн материал	667,900.00	667,900.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,257,385.77	11,000,000.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,257,385.77	11,000,000.16
392	Биет хөрөнгө	8,257,385.77	11,000,000.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,500,000.00	20,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,666,666.56	-20,499,999.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,408,720.00	11,108,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,984,667.67	-5,408,720.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		5,300,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,113,785.77	11,867,200.16
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,133,450.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,133,450.00
413	Өглөг	-	1,133,450.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,133,450.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,113,785.77	10,733,750.16
51	Засгийн газрын хувь оролцоо	9,113,785.77	10,733,750.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,955,000.00	1,955,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,955,000.00	1,955,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,941,697.87	7,561,662.26
5121	Өмнөх үеийн үр дүн	5,941,697.87	5,941,697.87
5122	Тайлант үеийн үр дүн		1,619,964.39
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,217,087.90	1,217,087.90
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,113,785.77	11,867,200.16

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	105,361,700.00	207,046,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,361,700.00	207,046,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,361,700.00	207,046,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,361,700.00	207,046,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	113,208,777.20	205,426,035.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,208,777.20	205,426,035.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,864,782.08	153,373,343.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,040,373.00	115,032,980.00
210101	Үндсэн цалин	70,040,373.00	115,032,980.00

**Архангай аймгийн Хайрхан сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,751,511.88	13,809,168.28
210201	Тэтгэврийн даатгал	5,951,226.35	9,531,091.44
210202	Тэтгэмжийн даатгал	700,404.45	1,059,016.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	560,324.17	876,320.06
210204	Ажилгүйдлийн даатгал	138,743.28	218,026.29
210205	Эрүүл мэндийн даатгал	1,400,813.63	2,124,714.41
2104	Хангамж, бараа материалын зардал	6,100,020.00	6,570,450.00
210401	Бичиг хэрэг	1,342,100.00	2,404,450.00
210402	Тээвэр, шатахуун	4,478,920.00	3,780,000.00
210404	Ном, хэвлэл	129,000.00	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	320,000.00
2107	Томилолт, зочны зардал	987,400.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	987,400.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,090,900.00	5,010,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,945,900.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	2,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	15,000.00	13,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,894,577.20	11,759,785.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,047,500.00	3,502,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,847,077.20	8,257,385.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,343,995.12	52,052,691.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	15,750,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	15,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	8,754,980.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,754,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,343,995.12	27,547,711.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,343,995.12	27,547,711.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-7,847,077.20	1,619,964.39
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,847,077.20	1,619,964.39

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	105,361,700.00	207,046,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,361,700.00	207,046,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,361,700.00	207,046,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,361,700.00	207,046,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	105,361,700.00	196,046,000.00

Архангай аймгийн Хайрхан сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,361,700.00	196,046,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,017,704.88	143,993,308.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,040,373.00	113,899,530.00
210101	Үндсэн цалин	47,510,210.00	76,024,315.00
210102	Нэмэгдэл	18,436,566.00	37,875,215.00
210104	Урамшуулал	4,093,597.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,751,511.88	13,809,168.28
210201	Тэтгэврийн даатгал	5,951,226.19	9,531,091.44
210202	Тэтгэмжийн даатгал	700,404.49	1,059,016.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	560,324.60	876,320.06
210204	Ажилгүйдлийн даатгал	138,742.89	218,026.29
210205	Эрүүл мэндийн даатгал	1,400,813.71	2,124,714.41
2104	Хангамж, бараа материалын зардал	6,100,020.00	6,583,650.00
210401	Бичиг хэрэг	1,342,100.00	2,415,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,478,920.00	3,780,000.00
210404	Ном, хэвлэл	129,000.00	68,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	320,000.00
2107	Томилолт, зочны зардал	987,400.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	987,400.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,090,900.00	5,010,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,945,900.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		50,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	2,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	15,000.00	13,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,047,500.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,047,500.00	3,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,343,995.12	52,052,691.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	15,750,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	15,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	8,754,980.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,754,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,343,995.12	27,547,711.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,343,995.12	27,547,711.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	11,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	11,000,000.00
	Дотоод эх үүсвэрээр	-	11,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	11,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-11,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,955,000.00	1,217,087.90	5,941,697.87	9,113,785.77
2	Тайлант үеийн үр дүн			1,619,964.39	1,619,964.39
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,955,000.00	1,217,087.90	7,561,662.26	10,733,750.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	207,046,000.00	179,498,288.28	27,547,711.72	86.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,046,000.00	179,498,288.28	27,547,711.72	86.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	181,714,000.00	154,993,308.28	26,720,691.72	85.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,029,600.00	113,899,530.00	23,130,070.00	83.12
210101	Үндсэн цалин	137,029,600.00	76,024,315.00	61,005,285.00	55.48
210102	Нэмэгдэл		37,875,215.00	37,875,215.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,128,700.00	13,809,168.28	3,319,531.72	80.62
210201	Тэтгэврийн даатгал	11,647,500.00	9,531,091.44	2,116,408.56	81.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,370,300.00	1,059,016.08	311,283.92	77.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,096,200.00	876,320.06	219,879.94	79.94
210204	Ажилгүйдлийн даатгал	274,100.00	218,026.29	56,073.71	79.54
210205	Эрүүл мэндийн даатгал	2,740,600.00	2,124,714.41	615,885.59	77.53
2104	Хангамж, бараа материалын зардал	6,715,700.00	6,583,650.00	132,050.00	98.03
210401	Бичиг хэрэг	2,415,700.00	2,415,250.00	450	99.98
210402	Тээвэр, шатахуун	3,780,000.00	3,780,000.00		100
210404	Ном, хэвлэл	200,000.00	68,400.00	131,600.00	34.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	320,000.00	320,000.00		- 100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	11,000,000.00		- 100
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000,000.00	5,700,000.00	5,300,000.00	51.82
210602	Тавилга		5,300,000.00	-5,300,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	1,190,000.00	10,000.00	99.17
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	1,190,000.00	10,000.00	99.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,140,000.00	5,010,960.00	129,040.00	97.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	4,500,000.00		- 100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	50,000.00	50,000.00	50
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	2,100.00	77,900.00	2.63
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	45,000.00		- 100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	15,000.00	13,860.00	1,140.00	92.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	400,000.00		- 100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00	-	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	3,500,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,332,000.00	24,504,980.00	827,020.00	96.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,750,000.00	15,750,000.00	-	100
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,750,000.00	15,750,000.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,582,000.00	8,754,980.00	827,020.00	91.37
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	8,754,980.00	827,020.00	91.37
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	207,046,000.00	179,498,288.28	27,547,711.72	86.69
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	207,046,000.00	179,498,288.28	27,547,711.72	86.69
132001	Орон нутгийн төсвөөс	207,046,000.00	179,498,288.28	27,547,711.72	86.69
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	3	3		100
6	Удирдах ажилтан	2	2		100
7	Гүйцэтгэх ажилтан	1	1		100

### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хайрхан сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 169 мэдээллээс 164 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулж, 5 сая төгрөгөөс дээш нийт 11,000.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, төсөв өмч хөрөнгө зарцуулах 25,593.7 мянган төгрөгийн 11 шийдвэрийг шилэн дансны цахим системд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.5- д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй. Харин аудитаар залруулаагүй 18,582.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 875.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 17,706.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг дүн нь 18,582.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 2,329.3 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Хайрхан сумын ИТХ-ын даргын 2024 оны 04 дугаар сарын 14-ны өдрийн Б/05 дугаар захирамжаар нарийн бичгийн даргад 8,755.0 мянган төгрөгийг хөдөө нутагт тогтвор суурьшилтай ажилласан үндэслэлээр олгосон бөгөөд урамшууллаас хувь хүний орлогын албан татвар 10 хувь болох 875.5 мянган төгрөгийг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

#### 3.2 Албан шаардлага

3.2.1. Хайрхан сумын ИТХ-ын даргын 2024 оны 09 дугаар сарын 26-ны 15 дугаар захирамжаар 2 албан хаагчид нийт 700.0 мянган төгрөгийн, Хайрхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны 12 дугаар тушаалаар 1 албан хаагчид нийт 350.0 мянган төгрөг, нийт 1,050.0 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

3.2.2 Тайлант хугацаанд 13,750.0 мянган төгрөгийн шатахуун, 2,000.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, нийт 15,750.0 мянган төгрөгийг ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалд зарцуулсныг анхан шатны баримтаар тулган шалгахад төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тойрогт ажилласныг нотлох ажлын болон төсвийн зарцуулалтын тайлангүй, төлөөлөгч нар жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тушаалаар баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.7-д “Төлөөлөгчийн үйл ажиллагаа, чадавхжуулах арга хэмжээнд шаардагдах зардлын төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа төлөөлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт зардлыг тухай бүр олгоно”, 4.1-д "Төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Хурлын ажлын албанд тухай бүр гаргаж өгнө" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2.3 Цалингийн зардлыг хянаж үзэхэд 2024 оны 3 дугаар сарын ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 906.9 мянган төгрөгийг цалингийн сангаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

3.2.4 Шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудаснаас хөөн шалгахад жолоочийн тооцооны хуудсыг шатахуун зарцуулсан холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно“, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” -ын 6 дугаар зүйлийн 6.4-т заасан жолоочийн тооцооны хуудас нөхөх зааварт "хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна,тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр шатахууны хэтрэлт, хэмнэлтийг гаргана" гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Мөнгөн урамшууллаас ХХОАТ-ын 10 хувийг суутгаагүй	1	875.5	1	875.5						
Цалингийн сангаас түлшний хөнгөлөлт олгосон	1	1050.0			1	1050.0				
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	15750.0			1	15750.0				
Цалингийн сангаас ажил олгогчоос төлөх НДШ-ийг шилжүүлсэн	1	906.9			1	906.9				
Жолоочийн тооцооны хуудас хөтлөлт хангалтгүй, хяналт тавьж ажиллаагүй	1	0			1	0				
Дүн	5	18582.4	1	875.5	4	17706.9				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны системд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	0	1	0				
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	1	0				